

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Тайлан бэлтгэсэн: Ж.БОЛОРМАА

Миний бие тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнд орж ажиллалаа.

Төлөөлөн удирдах зөвлөл болон дээр дурьдсан хороодын ээлжит болон ээлжит бус хурлуудад цахимаар, бичгээр санал өгөх аргаар оролцож, холбогдох асуудалд саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дараах хугацаанд хуралдав.

- 1.1. 2026.01.13-ны өдөр
- 1.2. 2026.01.29-ний өдөр
- 1.3. 2026.02.12-ны өдөр
- 1.4. 2026.02.13-ны өдөр
- 1.5. 2026.03.03-ны өдөр
- 1.6. 2026.03.12-ны өдөр
- 1.7. 2026.03.23-ны өдөр
- 1.8. 2026.03.30-ны өдөр
- 1.9. 2026.04.09-ний өдөр
- 1.10. 2026.04.14-ний өдөр
- 1.11. 2026.04.24-ний өдөр
- 1.12. 2026.05.14-ний өдөр
- 1.13. 2026.05.21-ний өдөр
- 1.14. 2026.06.16-ны өдөр
- 1.15. 2026.06.25-ны өдөр
- 1.16. 2026.06.26-ны өдөр

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. ТУЗ-ийн дарга сонгох;
2. ТУЗ-ийн хороодын дарга, гишүүдийг сонгох, чөлөөлөх;
3. ХХБ-ны сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журамд өөрчлөлт оруулах;
4. Худалдаа, хөгжлийн банкны 2025 оны 4 дүгээр улирал болон 2026 оны 1-р улирлын гүйцэтгэлтэй танилцах;
5. Залилангийн эсрэг бодлого батлах;
6. ХЭ-ийн ээлжит хурал зарлах;

7. ХХБ-ны аудитлагдсан санхүүгийн тайланг хүлээн авах тухай;
8. Банкны санхүүгийн төсөвт тодотгол хийх;
9. Худалдаа, хөгжлийн банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлантай танилцах;
10. Сонирхлын зөрчилтэй 8 хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
11. АХорооны дүрэм, Дотоод аудитын бодлого, Дотоод аудиторуудын ёс зүйн дүрэм, ДАГ-ын журмыг шинэчлэн батлах;
12. Худалдаа, хөгжлийн банкны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай асуудал;
13. Худалдаа, хөгжлийн банкны үндсэн хөрөнгө, БЗХ, ӨБХХ, ӨБҮХХ-д бүртгэлтэй хөрөнгүүдийг зарах зөвшөөрөл олгох;
14. Тогтворжуулах төлөвлөгөөг хэлэлцэн батлах;
15. Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэх бусад асуудал.

Тайлант хугацаанд ЦУНДХ нь нийт 7 удаа хуралдаж, Банкны 2026 онд мөрдөх орон тоо, цалингийн сан, тус хорооны 2025 оны ажлын тайлан болон 2026 оны ажлын төлөвлөгөө, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Банкны 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг үнэлэх, ГУ-ын гүйцэтгэлийн үнэлгээ, Бүтээгдхүүн хөгжлийн хороонд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэснээс гадна Банкны зохистой засаглалын нийцлийн аудитын үр дүнгээс ЦУБНДХ-ны үйл ажиллагаанд хамаарах хэсгийн тайлантай танилцан цаашид хийх ажил, сайжруулах журам зохицуулалтын талаар холбогдох албан тушаалтанд үүрэг өгсөн болно.

АХ-ны гишүүн болон даргаар ажиллах хугацаанд тус хороо нь нийт 4 удаа хуралдаж, Тогтворжуулах төлөвлөгөө 2026-д хийсэн аудитын дүгнэлт, АХ-ны дүрэм, Дотоод аудитын бодлого, Аудиторуудын ёс зүйн дүрэм, ДАГ-ын журмын шинэчилсэн найруулгын төсөл болон нэмэлт өөрчлөлтийн төсөл зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны хурал 2026 оны 3 дугаар сарын 27, 4 дүгээр сарын 9 ба 23-ны өдрүүдэд хуралдаж, Банкны зээлийн шинэчилсэн бодлогын төсөл, Банкны 2026 оны тогтворжуулах төлөвлөгөөний төсөл, Эрсдэлийн аппетитын 1 дүгээр улирлын гүйцэтгэл зэрэг асуудлыг хэлэлцлээ.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлаас гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан. Тайлант хугацаанд

буюу 2026 оны эхний хагас жилд нийт 8 сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан. Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал ТУЗ-ийн хуралд танилцуулагдаагүй.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан гишүүний эрх, чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан шаардлага байгаагүй ба хэлэлцсэн асуудлаар тавьсан саналыг ТУЗДАА болон Банкны удирдлага, газар нэгжүүд хүлээн авч тухай бүр засаж залруулж, хэрэгжүүлж явсан бөгөөд Банкны үр дүнтэй засаглал, комплайнсыг хангах, сайн туршлагыг хэрэгжүүлэхийг зорин ажиллаа.

Тайлан бэлтгэсэн: Д.ГАНТӨГС

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит болон ээлжит бус дараах хурлуудад цахимаар оролцох болон тогтоолын төсөлд бичгээр саналаа өгөх хэлбэрээр холбогдох шийдвэр гаргахад саналаа өгч ажилласан. Зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлууд дараах хугацаанд хуралдав.

- 2.1. 2026.05.14-ний өдөр
- 2.2. 2026.05.21-ний өдөр
- 2.3. 2026.06.16-ны өдөр
- 2.4. 2026.06.25-ны өдөр
- 2.5. 2026.06.26-ны өдөр

3. Аудитын хорооны дараах хуралд оролцов.

- 3.1. 2026.06.02-ны өдөр.
- 3.2. 2026.06.03-ны өдөр

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө хууль дээдлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэх, хамгаалах зарчимд үндэслэн Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

16. ТУЗ-ийн даргыг сонгох;
17. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
18. ХХБ-ны засаглалтай холбоотой бодлого, журмуудыг батлах;
19. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;
20. Банкны зарим хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
21. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт татах зөвшөөрөл олгох зэрэг асуудлууд болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй 8 хэлцлүүд ТУЗ-н хурлаар орж хэлэлцэгдэн, тухай бүрд хуралд оролцож өөрийн саналыг өгч оролцлоо. Эдгээр сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хэлэлцэх явцад ТУЗ-н хараат бус гишүүний үүргийн хүрээнд хууль эрх зүйд нийцтэй байдал, Монголбанкны тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах байдал, комплайнсын хүрээнд нийцтэй зэргийг тодруулж, тайлбар авч ажиллалаа.

Тайлант хугацаанд хуралд оролцохдоо дараах чиглэлээр асуулт асуух, санал, зөвлөмж хэлэх, үүрэг даалгавар өгөх байдлаар ажиллалаа. Үүнд:

- Сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцогч талын үйл ажиллагаа, гэрээний нөхцөл,
- Төсөл хөтөлбөрийн санхүүгийн үр ашгийн тооцооны асуудлаар;
- ТУЗ-н дэргэдэх хорооны дүрэм журамны хүрээнд.

Мөн аудитын хорооны гишүүний хувиар *Аудитын хорооны дүрэм, ДАГ-ын журам, Дотоод аудитын бодлого, Дотоод аудитруудын ёс зүйн дүрэм зэрэг бодлого, журмын шинэчилсэн төсөлд найруулга болон хууль, эрх зүйн нийцэлд анхаарах талаар зөвлөгөө өгч, саналаа хэлсэн болно.*

ТУЗ-ийн гишүүн, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Аудитын хорооны гишүүнээр ажиллахдаа Компанийн хууль, Банкны тухай хууль, МБ-ны журам, ХХБ-ны дүрмийг мөрдлөг болгон банкны үйл ажиллагаатай холбоотой ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зэрэг ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Тайлан бэлтгэсэн: Л.НЯМСҮРЭН

УДИРДАМЖ БОЛГОСОН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

- Компанийн тухай хууль,
- Монгол Улсын Банкны тухай хууль,
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-143 дугаар тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журам”,
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/86 дугаар тушаалаар батлагдсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”,
- ХХБ-ны Дүрэм
- Бусад холбогдох засаглалын бодлого, зарчмууд.

ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХАРИУЦАН ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ ҮҮРГҮҮД

- 2026 оны эхнээс ТУЗ -ийн хараат бус гишүүн, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Аудитын хорооны гишүүн, Цалин урамшуулал,болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн
- 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны даргаар томилогдон ажиллаж байна.

ОРОЛЦСОН ХУРЛУУД

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлууд, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны хурал,Эрсдэлийн удирдлагын хорооны хурал, Аудитын хорооны хуралд цахимаар оролцох болон тогтоолын төсөлд бичгээр саналаа өгөх хэлбэрээр холбогдох шийдвэр гаргахад саналаа өгч ажиллаа.

Энэ хугацаанд Компанийн хууль, Банкны тухай хууль, МБ-ны журам, ХХБ-ны дүрмийг мөрдлөг болгон ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зэрэг ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

ТУЗ-хурал

• 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр • 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдөр • 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр • 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр • 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр	• 2026 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр • 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр • 2026 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр • 2026 оны 05 дугаар сарын 14-ны өдөр • 2026 оны 05 дугаар сарын 21-ны өдөр • 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдөр • 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр • 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр
---	--

Хороодын хурал

Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо

• 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр • 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр • 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр	• 2026 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр • 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр • 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр
---	---

Аудитын хороо

•	• 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр
---	---------------------------------------

Эрсдэлийн удирдлагын хороо

• 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр	• 2026 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр • 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр
---	--

ТУЗ-ын хурлаар голчлон дараах сэдвүүдтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргасан.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүтэц өөрчлөх, гишүүдийг томилох;
- Банкны бүтэц зохион байгуулалт шинэчлэх;
- Банкны хэтийн болон цаг үеийн бодлого болон үйл ажиллагаатай холбоотой бодлого, журмуудыг батлах;
- Худалдаа хөгжлийн банкны эрсдэлийн түвшин, эрсдэлийн аппетит;
- Тогтворжуулах төлөвлөгөө 2026"-г батлах тухай;
- Худалдаа, хөгжлийн банкны төсвийн гүйцэтгэл, үйл ажиллагааны үзүүлэлтийн улирлын гүйцэтгэл;
- Худалдаа хөгжлийн банкны ТУЗ-ын дэргэдэх хороод болон зарим чиглэлийн үйл ажиллагааны тайлан;
- Хөндлөнгийн аудитын тайланг хүлээн авах;
- Зээлийн өр төлбөрт хураан авсан хөрөнгө худалдах;
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай;
- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай;
- ХХБ-ны санхүүгийн төсөвт тодотгол хийх тухай;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл;
- Гадны банктай хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай;

Шийдвэр гаргах үйл ажиллагаанд орлцохдоо асуудлуудтай холбоотой тодруулга хийх, нэмэлт судалгаа, материал гаргуулах, хариуцсан ажилтнуудаас тайлбар авах, банкны үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлөх эрсдэлийн хүчин зүйлээс сэргийлэх арга хэмжээнүүд авсан эсэхийг лавлах зэргээр ажиллаа. Тайлангийн хугацаанд дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, өөрийн итгэл үнэмшил дээр тулгуурлан шийдвэрийн төсөлд дэмжиж саналаа өгөв. Тайлангийн хугацаанд зарчмын зөрүүтэй саналууд гараагүй. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд асуудал шийдвэрлэхэд ТУЗ-ын ажлын алба, банкны гүйцэтгэх удирдлага, алба нэгжүүдээс шаардлагатай мэдээллүүдээр хангагдан ажиллаж байна.

ТУЗ болон түүний дэргэдэх хорооны хурлын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож дараах асуудлуудыг хөндөж саналаа хэлсэн болно.

- Эрсдэлийн хэтийн төлөвт макро түвшингийн нөлөөллийг судалж үзэх шаардлагатай байгаа тухай
- Эрсдэл, аудит, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаа, бодлого журмын төслүүдтэй холбоотой санал, зөвлөмж хэлсэн болно.
- Зээлийн судалгааг сайжруулах, чанаргүй зээлийн эзлэх хувийг бууруулах, зээл чанаргүйдэх, банк түүнээс болоод алдагдал хүлээхээс сэргийлэх асуудлыг банкны бүх түвшинд анхаарах тухай
- Цалин урамшуулал, болон нэр дэвшүүлэх хорооны журмын төслийг боловсруулж ТУЗ-аар батлуулахад идэвхтэй оролцлоо
- ТУЗ-ын дэргэдэх хороодын шийдвэрийг баталгаажуулах үйл ажиллагааг нэг загварт оруулах санал гаргав.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ:

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлд санал өгч ажиллаа.

Тайлангийн хугацаанд ийм төрлийн 8 асуудал ТУЗ-ийн хурлаар хэлэлцэгдэж шийдвэр гаргав.

Эдгээр асуудлууд банкны үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлөх эрсдэл байгаа эсэхийг өөрт байгаа мэдээлэл, шаардлагатай нэмэлт тодруулга дээр үндэслэн дүгнэлт гаргасаны дараа дэмжих санал өгч оролцсон болно.

ТУЗ гишүүн, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, ЦУБНДХ-ны хорооны дарга, гишүүнээр ажиллахдаа, хууль, дүрмийг мөрдлөг болгон банк түүний харилцагчид, хувьцаа эзэмшигч, ажилтны эрх ашигт нийцүүлэх зорилтыг ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд тавьж ажилласан болно.